

ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2018 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 2 ДАХЬ
ДОЛОО ХОНОГИЙН МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА

№ 12

2018.04.12.

Өлгий сум

Нэг: Аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал.

Тус Цагдаагийн газар энэ 7 хоногийн хугацаанд гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 58 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан бөгөөд 10 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн.

Мөн 3 гомдол, мэдээлэлд хэрэг нээхээс татгалзсан.

Хулгайлах хэрэг 5, хүний эрүүл мэндэд хохирол учруулах хэрэг 10, бусад төрлийн 4 хэрэг тус тус бүртгэгдсэн.

Нийт 198 зөрчил илрүүлж, зөрчил үйлдсэн 173 хүнд 7835000 төгрөгийн тогуулийн шийтгэл оногдуулсан, 8 хүн баривчлагдсан, 25 хүн эрүүлжүүлэгдсэн.

Хоёр: Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх болон бусад чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ.

Тус Цагдаагийн газар нь 2018 оны эхний 3 сарын байдлаар нийт 627 гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1.9 хувиар өссөн.

Тус аймгийн нутаг дэвсгэрт 2018 оны эхний 3 сарын байдлаар нийт 57 холбогдогчтой, 44.0 сая төгрөгний хохиролтой, 110 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд гэмт хэргийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 27 хэрэг буюу 32.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 4 нэгж буюу 16 хувиар, бусдын эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг 2 нэгж буюу 4.7 хувиар, автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих хэрэг 2 нэгж буюу 50 хувиар тус тус буурсан, залилах хэрэг 2 нэгж буюу 66.6 хувиар, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх хэрэг 3 нэгж буюу 42.8 хувиар, согтуугаар үйлдэгдсэн хэрэг 2 нэгж буюу 14.2 хувиар, бусад төрлийн гэмт хэрэг 13 нэгж буюу 76 хувиар, хүүхэд оролцсон гэмт хэрэг 6 нэгж буюу 85.7 хувиар, хөрөнгө завших хэрэг 6 нэгж буюу 85.7 хувиар тус тус өгч, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах, хүн худалдаалах, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг бүртгэгдээгүй.

1. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх баруун бүсийн нэгдсэн сургалт, зөвлөгөөнийг 2018 оны 06 дугаар сард зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар байгуулах нь зүйтэй байна.

2. Архидан согтуурахтай тэмцэх ажлыг бүх шатандаа хэрэгжүүлэх шаардлагатай байна. 2018 оны эхний 3 сарын хугацаанд 273 хүн саатуулагдсан бөгөөд үүнийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 141 хүн буюу 51.6 хувиар, баривчлагдсан хүний тоо 16 хүнээр буюу 27.1 хувиар тус тус өссөн байна.